

**САЛБАРЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТАЙЛАНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ДҮН**

2026.06.23

Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний холбогдох 5 стратегийн зорилгын хүрээний 33 зорилт арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Тус газрын гүйцэтгэлийн тайланг "Журам батлах тухай" Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын 2.4, 2.5-т заасан аргачлалаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Хүрэх түвшин нь 01-12 сар (жилийн) болж заасан арга хэмжээг хагас жилийн байдлаар үнэлэхдээ зорилтот түвшинг 50%-иар хуваан авч, гүйцэтгэлтэй харьцуулан тооцоо.

Гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ холбогдох аргачлалын дагуу батлагдсан төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшинг тус тус харгалзан үзсэн.

Хүснэгт-1

№	Төлөвлөлтийн хэсэг	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Гүйцэтгэлийн үнэлгээний дундаж хувь /өөрсдийн үнэлсэн/	ХШУДАГ-аас өгсөн үнэлгээ
1	Зорилт 1. Зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хялбаршуулж, ил тод, нээлттэй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид болгох, иргэн, аж ахуйн нэгжид үзүүлэх үйлчилгээг бүрэн цахимжуулсан тогтолцоог бүрдүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавих	1	1	100%	90%
2	Зорилт 2. Зөвшөөрлийн жагсаалтыг жил бүр шинэчлэх, хасах/нэмэх саналыг нэгтгэж Зөвшөөрлийн зөвлөлд эсвэл Засгийн газарт танилцуулах, шийдвэрлүүлэх; хуульд заасан заавар журмыг боловсруулж, батлуулах	1	1	70%	60%
3	Зорилт 3. Бүх зөвшөөрлийг "E-License" нэгдсэн платформд нэгтгэхэд бодлогын дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавих	1	1	100%	100%
4	Зорилт 4. Газар, түүний нөөцийг зохистой, үр дүнтэй ашиглах, иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод газрын харилцааны орчин бүрдүүлж, газар өмчлөлийг эрчимжүүлэх ажлын шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх, хяналт тавих	1	1	100%	100%

5	Зорилт 5. Засгийн газар нийгэм, эдийн засгийн томоохон асуудлаар шийдвэр гаргахын өмнө иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас цахим хэлбэрээр санал авах, хэлэлцүүлэх нөхцөлийг "И-Монголиа" системд түшиглэн бүрдүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавих	1	1	100%	100%
6	Зорилт 6. Иргэн, аж ахуйн нэгжээс төрд байгаа мэдээллийг шаардахгүй байх мэдээллийн жагсаалтыг гаргаж, зохицуулалтын орчныг сайжруулан, цахим хэлбэрт шилжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавих	1	1	100%	100%
7	Зорилт 7. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулахад дэмжлэг үзүүлэн, ЗГ-ын хуралдаанд хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэх	1	1	-	Үнэлэх боломжгүй
8	Зорилт 8. Газрын хэвлийн баялгаас иргэдийн хүртэх үр өгөөжийг бодитоор нэмэгдүүлж, эхний ээлжинд хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дэмжлэг олгоход бодлогын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих	1	1	100%	100%
9	Зорилт 9. Стратегийн 17 орд болон томоохон ордуудын өгөөжийг ард иргэдэд шударгаар хүртээх болон үндэсний баялгийн санд орлого төвлөрүүлэх ажлыг үе шаттайгаар шийдвэрлэхэд бодлогын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих	1	1	-	Үнэлэх боломжгүй
10	Зорилт 10. Үндэсний баялгийн сангийн хөрөнгө оруулалтын бодлогыг олон улсын зарчмуудтай уялдуулан шинэчлэхэд бодлогын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих	1	1	-	Үнэлэх боломжгүй
11	Зорилт 11. Орлого төвлөрүүлэгч байгуулагуудын санхүүгийн ил тод байдал, менежментийг сайжруулахад бодлогын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих	1	1	100%	100%
12	Зорилт 12. Эрдэнэтийн овоо ордын үүсмэл ордыг ашиглаж байгаа хуулийн этгээдүүдтэй төрийн эзэмшлийн хувьцааны хувь хэмжээг тогтоох хэлэлцээг хийх	1	1	-	Үнэлэх боломжгүй

13	Зорилт 13. "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн баяжуулах үйлдвэрийн конвейрын систем	1	1	100%	100%
14	Зорилт 14. Тавантолгойн бүлэг ордын ашиглагдаагүй байгаа хэсгийг эдийн засгийн эргэлтэнд оруулах	1	1	100%	85%
15	Зорилт 15. Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төсөл	1	1	100%	100%
16	Зорилт 16. Гангийн үйлдвэрлэлийн цогцолборын төсөл	1	1	-	Үнэлэх боломжгүй
17	Зорилт 17. Хөтөлийн цемент шохойн үйлдвэрийн бүтээн байгуулалтыг дуусгах	1	1	-	Үнэлэх боломжгүй
18	Зорилт 18. Жоншны баяжуулах үйлдвэрийн төсөл	1	1	-	Үнэлэх боломжгүй
19	"Нүүрс химийн цогцолбор (хөх нүүрсний үйлдвэр)" төсөл	1	1	-	Үнэлэх боломжгүй
20	"Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль", "Нийтийн өмчийн тухай хуулийн" төслүүдийг боловсруулан УИХ-д өргөн мэдүүлэх	1	1	100%	100%
21	Зорилт 21. Төрийн болон орон нутгийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлэхэд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих	1	1	100%	90%
22	Зорилт 22. Төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны бүртгэл, мэдээллийн ил тод байдлыг бүрэн хангуулахад зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих	1	1	100%	100%
23	Зорилт 23. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем бий болгох, хөгжүүлэхэд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих	1	1	100%	100%
24	Зорилт 24. Төрийн өмчит зарим компаниудыг олон нийтийн хяналтад оруулах, тодорхой хувийг хувьчлах, өөрчлөн байгуулах, хувьцааг нь нээлттэйгээр биржээр дамжуулан борлуулахад дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих	1	1	-	Үнэлэх боломжгүй
25	Зорилт 25. Хувьцаа эзэмшигчийн эрхийг 100 хувь хэрэгжүүлдэг төрийн өмчийн компаниудад дэмжлэг үзүүлж, үйл ажиллагааг сайжруулах	1	1	100%	100%

26	Зорилт 26. Төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагын ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх, танилцуулах асуудлыг хянаж, ЗГХЭГ-ын саналыг бэлтгэж, удирдлагыг зөвлөгөө, мэдээллээр хангах	1	1	100%	100%
27	Зорилт 27. ЗГ-ын тогтоол, шийдвэрийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах; хууль тогтоомж, ЗГ-ын шийдвэрийн төсөлд хууль зүйн мэргэжлийн дэмжлэг үзүүлэх	1	1	100%	70%
28	Зорилт 28. Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх ажлын шийдвэр гаргалтад бодлогын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх	1	1	90%	80%
29	Зорилт 29. Хувийн өмчийн халдашгүй байдлыг төрөөс бүрэн хамгаалж, бизнесийн үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөх, хуульб усаар өмч хураах, албадан хариуцлага хүлээлгэхийг хориглох эрх зүйн орчныг бүрдүүлэх	1	1	100%	80%
30	Зорилт 30. ЗГ-ын тогтоол, ЕС-ын захирамж, сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгүүдийг уялдаа, удирдлага зохицуулалтаар хангаж, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх	1	1	100%	100%
31	Зорилт 31. Хууль тогтоомж, ЗГ-ын шийдвэрийн хэрэгжилтийг яам, ЗГ-ын агентлагийн түвшинд уялдуулан зохицуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавих	1	1	100%	80%
32	Зорилт 32. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, салбаруудын эрх зүйн орчныг шинэчлэх, төрийн албан дахь хүйсийн тэнцвэрт байдлыг хангах ажлын шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх, хяналт тавих	1	1	-	Үнэлэх боломжгүй
33	Зорилт 33. Иргэн, хуулийн этгээд, төрийн бусад байгууллагаас ЕС, ЗГХЭГ-ын удирдлагад хандаж ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг судалж, хуульд заасан хугацаанд хариу өгч, шийдвэрлэх	1	1	100%	92%
Дундаж ерөнхий үнэлгээ		23	23	98%	92%

Хүснэгт-2

Газар, хэлтэс	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	85 буюу түүнээс дээш хувь бол "бүрэн хангалттай" (арга хэмжээ оновчтой тодорхойлогдсон, зорилтот түвшинд нь хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан, эсхүл шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд нь бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн)	70-85 хүртэл хувь бол "хангалттай" (шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд нь бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах)	70 хүртэл хувь бол "хангалтгүй" (удирдлага, зохион байгуулалт хангалтгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй нь баримтаар нотолгоотой.)
СБЗГ	23	23	18	4	1

ДҮГНЭЛТ

Салбарын бодлого, зохицуулалтын газраас 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланг **98%** хувиар үнэлж ирүүлснийг хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж **92%** хувиар үнэлэв.

Үнэлгээг хамарсан 23 зорилтоос "бүрэн хангалттай" ($\geq 85\%$) — 18 зорилт, "хангалттай" (70-85%) — 4 зорилт, "хангалтгүй" ($< 70\%$) — 1 зорилт тус тус авсан. 10 зорилт нь удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу өөр нэгж хариуцаж байгаа шалтгааны улмаас "үнэлэх боломжгүй" гэж тооцлоо.

Салбарын бодлого, зохицуулалтын газрын 2026 оны эхний хагас жилд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлаас онцолбол:

- "e-zasag.mn" хэрэглээг нэвтрүүлж, иргэдийн санал санаачилга, хэлэлцүүлгийн тогтолцоог ЗГ-ын шийдвэрээр (2026.06.17) баталгаажуулсан.
- "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэрийн конвейер, бутлуурын систем 2026.02-д ашиглалтад орсон.
- Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын явц 30%-д хүрч, ЗГ-ын 59, 69 дугаар тогтоолоор эрх зүйн орчныг бүрдүүлсэн.
- ЗГ-ын хуралдаанд яамдын 414 асуудлыг оруулан хэлэлцүүлж ажилласан, жилийн зорилтот 620-ийн 50% болох 310-аас их.

Салбарын бодлого, зохицуулалтын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс анхаарах шаардлагатай ажлаас дурдвал:

- Зорилт 27 (70%): ЗГ-ын шийдвэрийн давхардал, хийдлийг арилгах ажлын тоон үзүүлэлтийг баталгаажуулж, хоёрдугаар хагас жилд ажлын хэсэг байгуулах шаардлагатай.
- Удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу өөр нэгж хариуцаж буй 10 зорилтын талаар гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах

ЗӨВЛӨМЖ


- ЗГ-ын шийдвэрийн давхардал, хийдлийг арилгах талаар ХШҮДАГ болон ХЭЗГ-ийн оролцоотойгоор тодорхой хуваарь, хэмжилт үзүүлэлт гарган ажиллаж хоёрдугаар хагас жилд хэрэгжүүлэх.
- "Чөлөөлье" санаачилгын хүрээний яам, агентлагуудаас ирүүлсэн саналыг нэгтгэн жагсаалтыг хугацаатай төлөвлөгөө гаргах.
- Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүгнэлт, зөвлөмжийн дагуу зорилтот түвшинд хүрээгүй арга хэмжээг үлдсэн хагас жилийн хугацаанд эрчимжүүлэн ажиллах.

ХЯНАСАН:



ДЭД ДАРГА С.БАТБОЛД

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:



ЗАСГИЙН ГАЗРЫН РЕФЕРЕНТ
Б.ОРГИЛ

Хавсралт

Хүснэгт-3

**САЛБАРЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ДҮН
/ЗААЛТ БҮРИЙН ҮНЭЛГЭЭ/**

Арга хэмжээний д/д	Арга хэмжээний дугаар	Өөрсдийн өгсөн үнэлгээ	ХШҮ хийсэн үнэлгээ	Үнэлгээний тайлбар
Зорилт 1. Зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хялбаршуулж, ил тод, нээлттэй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид болгох, иргэн, аж ахуйн нэгжид үзүүлэх үйлчилгээг бүрэн цахимжуулсан тогтолцоог бүрдүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавих				
1	1.1	100	90	Цахимаар олгож буй зөвшөөрлийн эзлэх хувь 92%-д хүрсэн (зорилт 90%).
Зорилт 2. Зөвшөөрлийн жагсаалтыг жил бүр шинэчлэх, хасах/нэмэх саналыг нэгтгэж Зөвшөөрлийн зөвлөлд эсвэл Засгийн газарт танилцуулах, шийдвэрлүүлэх; хуульд заасан заавар журмыг боловсруулж, батлуулах				
2	2.1	70	60	Хууль санаачлагчаас ирүүлсэн 4 асуудлын шийдвэрийн төслийг бэлтгэсэн боловч Зөвшөөрлийн зөвлөл ЗГ-ын бүрэлдэхүүний өөрчлөлттэй холбоотойгоор хуралдаагүй. Зөвшөөрөл шинээр үүсгэхтэй холбогдох аргачлалыг 2026.04.29-ний ЗГ-ын хуралдаанд хэлэлцүүлж 155 тогтоол гаргасан. Зөвлөл хуралдаагүй шалтгаан нь газрын хяналтаас гадуур боловч зорилтот түвшин хангагдаагүй тул 60% үнэлэв.
Зорилт 3. Бүх зөвшөөрлийг "E-License" нэгдсэн платформд нэгтгэхэд бодлогын дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавих				
3	3.1	100	100	E-license.mn-д нийт 371 зөвшөөрлөөс 344 нь бүрэн орсон.
Зорилт 4. Газар, түүний нөөцийг зохистой, үр дүнтэй ашиглах, иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод газрын харилцааны орчин бүрдүүлж, газар өмчлөлийг эрчимжүүлэх ажлын шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх, хяналт тавих				
4	4.1	100	100	Эзэмшүүлэх/ашиглуулах газрын жагсаалт батлах тогтоол, Газрын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл, Атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх тухай, Ган үйлдвэрлэлийн цогцолборт 651.2 га газар авах асуудал, Газрын нэгдмэл сангийн 2025 оны тайланг ЗГ хуралдаанаар хэлэлцүүлж, нийт 5 шийдвэр гарган ажилласан.
Зорилт 5. ЗГ нийгэм, эдийн засгийн томоохон асуудлаар шийдвэр гаргахын өмнө иргэн, аж ахуйн нэгж, байгуулагаас цахим хэлбэрээр санал авах, хэлэлцүүлэх нөхцөлийг "И-Монголиа" системд түшиглэн бүрдүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавих				
5	5.1	100	100	"e-zasag.mn" хэрэглээг нэвтрүүлж иргэдийн санал санаачилга, хэлэлцүүлэг, "Ерөнхий сайдаас асууя" буланг ажиллуулсан. 2026.06.17-ны ЗГ хуралдаанаар 14 хоног тутам 11-11 төвтэй нэгтгэн ЗГ-д танилцуулах тогтолцоог баталсан. Санал авах журамд өөрчлөлт орсон (тийм), санал авах процесс 100% цахим болсон.

Зорилт 6. Иргэн, аж ахуйн нэгжээс төрд байгаа мэдээллийг шаардахгүй байх мэдээллийн жагсаалтыг гаргаж, зохицуулалтын орчныг сайжруулан, цахим хэлбэрт шилжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавих				
6	6.1	100	100	ЗГ-ын 2026.01.07-ны хуралдаанаар Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 24.2 заалтын дагуу e-mongolia.mn-ээр үзүүлэх зохицуулалтыг өргөтгөн тусгасан. Жагсаалт батлагдсан (тийм), журамд өөрчлөлт орсон (тийм). Зорилт бүрэн хэрэгжсэн.
Зорилт 7. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулахад дэмжлэг үзүүлэн, ЗГ-ын хуралдаанд хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэх				
7	7.1	0	Үнэлэх боломжгүй	Асуудлыг удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу өөр нэгж хариуцаж байгаа болно.
Зорилт 8. Газрын хэвлийн баялгаас иргэдийн хүртэх үр өгөөжийг бодитоор нэмэгдүүлж, эхний ээлжинд хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дэмжлэг олгоход бодлогын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих				
8	8.1	100	100	"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Бортээг, Оюу толгой бүлэг ордын нөхцөл байдлын талаар ЗГ-ын хуралдаанд тухай бүр танилцуулж, тэмдэглэл гарсан.
Зорилт 9. Стратегийн 17 орд болон томоохон ордуудын өгөөжийг ард иргэдэд шударгаар хүртээх болон үндэсний баялгийн санд орлого төвлөрүүлэх ажлыг үе шаттайгаар шийдвэрлэхэд бодлогын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих				
9	9.1	0	Үнэлэх боломжгүй	Асуудлыг удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу өөр нэгж хариуцаж байгаа.
Зорилт 10. Үндэсний баялгийн сангийн хөрөнгө оруулалтын бодлогыг олон улсын зарчмуудтай уялдуулан шинэчлэхэд бодлогын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих				
10	10.1	0	Үнэлэх боломжгүй	Асуудлыг удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу өөр нэгж хариуцаж байгаа болно.
Зорилт 11. Орлого төвлөрүүлэгч байгууллагуудын санхүүгийн ил тод байдал, менежментийг сайжруулахад бодлогын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих				
11	11.1	100	100	"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцааг өвлөх эрхийн асуудал болон "Эрдэнэс Монгол" нэгдлийн шатахууны нөхцөл байдлыг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэн тэмдэглэл гарсан. Цахим нээлттэй байдал 70% (зорилт 70%), алдаагүй тайлагнал 85% (зорилт 85%). Бүх үзүүлэлт зорилтот түвшинд хүрсэн.
Зорилт 12. Эрдэнэтийн овоо ордын үүсмэл ордыг ашиглаж байгаа хуулийн этгээдүүдтэй төрийн эзэмшлийн хувьцааны хувь хэмжээг тогтоох хэлэлцээ хийх				
12	12.1	0	Үнэлэх боломжгүй	Асуудлыг удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу өөр нэгж хариуцаж байгаа болно.
Зорилт 13. "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн баяжуулах үйлдвэрийн конвейрын систем				
13	13.1	100	100	"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэрийн тэжээлийн нүүрс тээврийн конвейер, бутлуурын систем 2026.02-д ашиглалтад орсон. Шалгуур үзүүлэлт (тийм) хэрэгжсэн.
Зорилт 14. Тавантолгойн бүлэг ордын ашиглагдаагүй байгаа хэсгийг эдийн засгийн эргэлтэнд оруулах				

14	14.1	100	85	Гэрээ байгуулах (тийм) шалгуур хэрэгжсэн. Ерөнхий сайдын 2026.05 дугаар захирамжаар ажлын хэсгийг байгуулсан. Гэвч бүтээн байгуулалтын явц 1% (зорилт 30%) байгаа нь жилийн зорилтот 30-ийн 50% болох 15-аас доогуур тул ХШУДАГ 85% үнэлэв.
Зорилт 15. Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төсөл				
15	15.1	100	100	ЗГ-ын 2026.02.25-ны 59 тогтоол (тээвэр зохион байгуулалтыг сайжруулах), 2026.03.04-ний 69 тогтоол (хил дамнасан төмөр замын хаалттай бүсийн түр журам)-ыг баталж мөрдүүлсэн. Бүтээн байгуулалтын явц 30% (зорилт 30%).
Зорилт 16. Гангийн үйлдвэрлэлийн цогцолборын төсөл				
16	16.1	0	Үнэлэх боломжгүй	Стратегийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах асуудлыг 2026.04.08-ны ЗГ хуралдаанд танилцуулсан боловч асуудлыг удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу өөр нэгж хариуцаж байгаа болно.
Зорилт 17. Хөтлийн цемент шохойн үйлдвэрийн бүтээн байгуулалтыг дуусгах				
17	17.1	0	Үнэлэх боломжгүй	Асуудлыг удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу өөр нэгж хариуцаж байгаа болно.
Зорилт 18. Жоншны баяжуулах үйлдвэрийн төсөл				
18	18.1	0	Үнэлэх боломжгүй	Асуудлыг удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу өөр нэгж хариуцаж байгаа болно.
"Нүүрс химийн цогцолбор (хөх нүүрсний үйлдвэр)" төсөл				
19	19.1	0	Үнэлэх боломжгүй	Асуудлыг удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу өөр нэгж хариуцаж байгаа болно.
"Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль", "Нийтийн өмчийн тухай хуулийн" төслүүдийг боловсруулан УИХ-д өргөн мэдүүлэх				
20	20.1	100	100	Хоёр хуулийн төслийг Засгийн газраас 2025.01.10-нд УИХ-д өргөн мэдүүлсэн. Зорилт хэрэгжсэн.
Зорилт 21. Төрийн болон орон нутгийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлэхэд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих				
21	21.1	100	90	"Авто замын засвар арчлалтын нэгтгэл" ТӨК, "Эрчист Монгол" ТӨХК татан буулгах, "Төвийн бүсийн хүнс" ТӨХК-ийг "Хөдөө аж ахуйн корпорац" ТӨХК-д нэгтгэх шийдвэрүүдийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, албажуулсан. 9.63% байгаа нь зорилтот 10%-аас бага боловч хагас жилийн явцыг харгалзан 90% үнэлэв.
Зорилт 22. Төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны бүртгэл, мэдээллийн ил тод байдлыг бүрэн хангуулахад зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих				
22	22.1	100	100	Үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэх 5 асуудлыг ЗГ-ын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэж, оруулан албажуулсан. Ил тод байдлын үнэлгээ 5 (зорилт 5)

Зорилт 23. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем бий болгох, хөгжүүлэхэд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих				
23	23.1	100	100	Төрийн өөрийн өмчийн байр, талбайн ашиглалт, түрээсийн гэрээний хэрэгжилтийн нөхцөл байдлыг ЗГ хуралдаанд танилцуулсан. Систем хөгжүүлэлт 80% (жилийн зорилтот 100-ийн 50% болох 50%-аас дэлгэрэнгүй хэрэгжсэн), өмч хөрөнгийн тооллого 100%.
Зорилт 24. Төрийн өмчит зарим компаниудыг олон нийтийн хяналтад оруулах, тодорхой хувийг хувьчлах, өөрчлөн байгуулах, хувьцааг нь нээлттэйгээр биржээр дамжуулан борлуулахад дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих				
24	24.1	0	Үнэлэх боломжгүй	Асуудлыг удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу өөр нэгж хариуцаж байгаа болно.
Зорилт 25. Хувьцаа эзэмшигчийн эрхийг 100 хувь хэрэгжүүлдэг төрийн өмчийн компаниудад дэмжлэг үзүүлж, үйл ажиллагааг сайжруулах				
25	25.1	100	100	"Эрдэнэс Монгол" ХХК, "Эрдэнэс Тавантолгой" ХК-аас Засгийн газрын хуралдаанд танилцуулах, хэлэлцүүлэхээр ирүүлсэн асуудлыг боловсруулахад оролцсон. Ашигт ажиллагааны чиглэлийн арга хэмжээг тухай бүр хэлэлцүүлж ажилласан.
Зорилт 26. Төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, танилцуулах асуудлыг хянаж, ЗГХЭГ-ын саналыг бэлтгэж, удирдлагыг зөвлөгөө, мэдээллээр хангах				
26	26.1	100	100	Яамдаас ирүүлсэн материалыг хянан үзэж, Засгийн газрын хуралдаанд 414 асуудлыг оруулан ажиллав. Жилийн зорилтот 620-ийн 50% болох 310-аас 414 нь их.
Зорилт 27. ЗГ-ын тогтоол, шийдвэрийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах; хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн төсөлд хууль зүйн мэргэжлийн дэмжлэг үзүүлэх				
27	27.1	100	70	Засгийн газрын шийдвэрийн төслийг хянахдаа өмнөх хууль тогтоомж, тогтоол шийдвэртэй давхардал, хийдэлгүй байхад анхаарах шаардлагатай. Шийдвэрийн давхардал, хийдлийн тоон үзүүлэлтийг 2025 оны дүнд үндэслэн 70% үнэлэв.
Зорилт 28. Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх ажлын шийдвэр гаргалтад бодлогын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх				
28	28.1	90	80	"Чөлөөлье" санаачилгын хүрээний яам, агентлагийн саналыг нэгтгэж байна. ХЭГ/1862 дугаартай албан бичгийг хүргүүлэн саналыг авч нэгтгэж байгаа. Ажил эхэлсэн боловч шийдвэр гарч бүрэн дуусаагүй тул 80% үнэлэв.
Зорилт 29. Хувийн өмчийн халдашгүй байдлыг төрөөс бүрэн хамгаалж, бизнесийн үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөх, хууль бусаар өмч хураах, албадан хариуцлага хүлээлгэхийг хориглох эрх зүйн орчныг бүрдүүлэх				
29	29.1	100	80	104 арга хэмжээ бүхий Ерөнхий сайдын албан даалгаврын төслийг бэлтгэн ЗГ-ын 2026.03.18-ны хуралдаанд танилцуулж, 04 дүгээр албан даалгавар гарсан. Төрийн

				албан хаагчийн чиг үүргийн давхардлыг арилгах, Төрийн өмчийг аж ахуйн нэгжийг нэгтгэх, хувьцааг арилжаалах даалгаврыг тусгасан. Зорилтын дагуу хэрэгжсэн ажил тайлагнаагүй байгаа тул 80% үнэлэв.
Зорилт 30. Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгүүдийг уялдаа, удирдлага зохицуулалтаар хангаж, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх				
30	30.1	100	100	Газрын тухай хуулийн төсөл боловсруулах дэд Ажлын хэсэг, "Богдхан төмөр зам" төслийн мэдээллийг ил болгох ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллаж (205-р тогтоол гарсан), "Улаанбаатар Төмөр зам" ХНН-ийн Ерөнхий хорооны 5 хуралд оролцож, Хөдөлмөрийн гурван талт 2026-2028 хэлэлцээрт дэмжлэг үзүүлж ажилласан.
Зорилт 31. Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг яам, агентлагийн түвшинд уялдуулан зохицуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавих				
31	31.1	100	80	ХЭЗГ-тай хамтран мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллав. Тоон үзүүлэлт баталгаажуагүй тул 80% үнэлэв.
Зорилт 32. Жөндөрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, салбаруудын эрх зүйн орчныг шинэчлэх, төрийн албан дахь хүйсийн тэнцвэрт байдлыг хангах ажлын шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх, хяналт тавих				
32	32.1	0	Үнэлэх боломжгүй	Жөндөрийн үндэсний хорооны ээлжит хуралдааныг 2026.03.06-нд зохион байгуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, 2 тогтоолын төслийг хянан, албажуулж ажилласан. Гэвч асуудлыг удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу өөр нэгж хариуцаж байгаа болно.
Зорилт 33. Иргэн, хуулийн этгээд төрийн бусад байгууллагаас Ерөнхий сайд, ЗГХЭГ-ын удирдлагад хандаж ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг судалж, хуульд заасан хугацаанд хариу өгч, шийдвэрлэх				
33	33.1	100	92	СБЗГ-ын хариуцсан чиг үүрэгт хамаарах 238 өргөдөл, гомдлоос 220 нь хугацаандаа шилжүүлэх, уламжлах, хариу өгч шийдвэрлэсэн (92.4%). 17 хяналтад, 1 санал байгаа. Хуульд заасан хугацаанд шийдвэрлэсэн хувийг үндэслэн 92% үнэлэв.
Нийт дундаж үнэлгээ		98%	92%	Зорилт 1 (90%), Зорилт 2 (60%), Зорилт 14 (85%), Зорилт 21 (90%), Зорилт 27 (70%), Зорилт 28 (80%), Зорилт 29 (80%), Зорилт 31 (80%), Зорилт 33 (92%). Зорилт 7, 9, 10, 12, 16, 17, 18, 19, 24, 32 — үнэлэх боломжгүй.